



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/19

Өмнөдэлгэр сум

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16.5, 16.5.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19 ны өдрийн 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28 ны өдрийн 82 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/135 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах албан хаагчдын цалинг тушаалын дагуу шинэчлэн гаргаж хавсралтаар баталсугай.

2.Цалингийн олговрыг холбогдох хууль, журмын дагуу бодож, цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Б.Сэр-Од)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналтын багийн гишүүн (Б.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан даргын 2026 оны 01 дүгээр сарын 22 ны өдрийн "Цалин шинэчлэн батлах тухай" А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцосугай.

ДАРГА



Ц.АРИУНТУНГАЛАГ